



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2019 оны 04 сарын 02 өдөр

Дугаар 34

Мандалговь

Хөрөнгө акталж, данснаас хасах  
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны 77 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн 6.2.1, 6.4 дэх хэсгийн 6.4.6 дахь заалт, 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсгийг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг: Өндөршил сумын Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 1,910,000 /нэг сая есөн зуун арван мянга / төгрөгийн балансын үнэтэй, үлдэгдэл өртөггүй эдэлгээний хугацаа дууссан бага оврын трактор, 5,103,000 /таван сая нэг зуун гурван мянга/ төгрөгийн балансын үнэтэй 4,252,500 /дөрвөн сая хоёр зуун тавин хоёр мянга таван зуу/ төгрөгийн үлдэгдэл өртөгтэй зорийг тус тус акталж данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

Хоёр: Эд хөрөнгийг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор акталж устган данснаас хассаны дараа холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэж, тогтоолын биелэлтийг 2019 оны 04 дүгээр сард багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэхийг Өндөршил сумын Засаг даргын тамгын газар (Б.Амгаланжаргал)-г даалгасугай.

Гурав: Энэхүү тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Аймгийн Засаг дарга (О.Бат-Эрдэнэ) -д үүрэг болгосугай.

ДАРГА  С.СҮХБААТАР



480219074